


БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН
2025 оны 12 дугаар сарын 01

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дугаар 10

2025 оны 12 дугаар сарын 01

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 11:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	ҮТП-тай гэрээ байгуулан ажиллаж буй “Мэйжүрмэнт” ХХК-иас хандиваар ирүүлсэн тавилга, эд хөрөнгийг, “Элемент” ХХК-иас ирүүлсэн суурин компьютерийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Дугаар 10

2025 оны 12 дугаар сарын 01

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 11:30 цагт эхэлж 12:00 цагт дуусгав.

Хуралд:

Дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	О.Чулуун-Эрдэнэ
Гишүүд	Г.Ганцэцэг
	Б.Түмэнжаргал
	Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: УТП-тай гэрээ байгуулан ажиллаж буй “Мэйжүрмэнт” ХХК-иас хандиваар ирүүлсэн тавилга, эд хөрөнгийг, “Элемент” ХХК-иас ирүүлсэн суурин компьютерийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх тухай

СОНССОН НЬ: 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр УТП-тай 2025 оны 08 сарын 13-ны өдөр 2025/20 дугаартай гэрээ байгуулан ажиллаж буй “Мэйжүрмэнт” ХХК хандиваар дараах тавилга тоног төхөөрөмж ирүүлэх хүсэлт тавьсан. Энэхүү хүсэлтийг хүлээн авч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх эсэх саналыг та бүхнээс авах гэж байна. Мөн “Элемент” ХХК хандиваар бидэнд i5 суурин компьютер өгөх хүсэлтээ ирүүлсэн байна.

Н.Пүрэвсүрэн: “Мэйжүрмэнт” ХХК-иас Ширээ 1ш – 2,195,000, Хурлын ширээ 1ш – 2,100,000, Сандал 10ш – 1,900,000, Дарга сандал 1ш – 320,000, нийт 6,515,000 төгрөг бүхий тавилга эд хогшлыг манайд хандиваар ирүүлсэн байна. Мөн “Элемент” ХХК-иас i5 суурин компьютер – 2,499,000 төгрөг ирүүлжээ. Эдгээр хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авч өдөр тутамдаа ашиглахад миний хувьд татгалзах зүйлгүй гэж үзэж байна. Манай парк ойрын хэдэн жил тавилга эд хогшил аваагүй, одоо хэрэглэж буй ширээ сандалнууд маань ихэнх нь ашиглах хугацаа дууссан байгаа. Мөн шинээр хүчин чадал сайтай компьютер ч бас хэрэгтэй байна.

Б.Түмэнжаргал: Миний хувьд татгалзах зүйлгүй. Хамтын ажиллагааны хүрээнд хандив ирүүлнэ гэдэг тухайн байгууллага биднийг хэр дэмжиж байна вэ гэдгийг харуулж байна.

О.Чулуун-Эрдэнэ: Та 2-той санал нэг байна. Бидэнд шинэ ширээ, сандал маш чухал шаардлагатай байна. Уулзалт зөвлөгөөн, хурал цуглаан, сургалт болох үед бид дутагдах зүйлгүй байх боломж бүрдэж байна. Татгалзах зүйлгүй ээ.

Б.Болортуяа: Тийм ээ. Манай парк 2-р давхраа ашиглалтанд оруулснаар өрөөний тоо нэмэгдэж тэр хэрээр тавилга эд хогшил, компьютер дутагдалтай байгаа. Тэдгээр өрөөнүүддээ тавих хэрэгтэй гэж бодож байна.

Г.Ганцэцэг: Надад бас татгалзах зүйл байхгүй ээ.

Н.Пүрэвсүрэн: За тэгвэл Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар дээрх эд хогшил, компьютерийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж авцгаая.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 11 дүгээр хуралдаанаар гишүүд 100 хувийн ирцтэй хуралдаж нийт 5 нэр төрлийн 14 ширхэг эд хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авч ашиглахаар шийдвэрлэв.
- Дээрх эд хөрөнгийг тоолон хүлээн авч, кодчлол үүсгэн өмчийн бүртгэлийн системд холбогдох журмын дагуу бүртгэж, цаашдын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Нарийн бичгийн дарга



Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан
мэргэжилтэн/